



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/219

Улаанбаатар хот

Газар эзэмших эрхийг дуусгавар
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/253 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрх дуусгавар болгох хүсэлт ирүүлсэн 5 (тав) иргэний газар эзэмших эрхийг хавсралтад зааснаар дуусгавар болгосугай.

2. Газар эзэмших эрх нь дуусгавар болж байгаа иргэдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариу мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавьж, ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2012 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/129 дүгээр захирамжийн Б.Оюунтунгалаг, 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/67 дугаар захирамжийн Г.Нямдаржаа, 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/32 дугаар захирамжийн Б.Амгаланбаяр, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/136 дугаар захирамжийн Т.Номин-Эрдэнэ, 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/99 дүгээр захирамжийн Э.Эрдэнэсүрэн нарт хамаарах заалтыг тус өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД